

**МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ  
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Байнгын хороогоор дэмжигдсэн саналууд:**

**Нэг.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн төслийн талаар:**

**1.Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

**“3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Даатгалтай холбогдсон нийтлэг харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

3.2.Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаатай холбогдсон энэ хуулийн 3.1-т зааснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.3.Малын индексжүүлсэн даатгалд малчин, мал бүхий иргэн, хуулийн этгээд даатгуулж болно.”

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар,  
Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

**2.Төслийн доор дурдсан агуулгатай 4.1.2 дахь заалтыг хасах:**

“4.1.2.“Малын эрсдэлийн даатгал” гэж малын эрсдэлийн хохирлыг нөхөн төлөх малын индексжүүлсэн даатгалын стандарт бүтээгдэхүүнийг; ”

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар,  
Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

**3.Төслийн 4.1.14, 4.1.15 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“4.1.14.“Малын давхар даатгалын гэрээ” гэж даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ давхар даатгалын компанид хэсэгчлэн шилжүүлэхээр харилцан тохиролцсон хэлцлийг;

4.1.15.“Олон улсын давхар даатгалын гэрээ” гэж давхар даатгалын компани нь даатгагчийн өмнө хүлээсэн үүргээ багцлан гадаад улсын давхар даатгалын компанид бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэхээр харилцан тохиролцсон хэлцлийг.”

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар,  
Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

4.Төслийн 4.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.7.Малын индексжүүлсэн даатгалын гэрээ /цаашид “даатгалын гэрээ” гэх/ гэж даатгагч нь даатгалын тохиолдол бий болоход энэ хууль болон гэрээнд заасны дагуу даатгалын нөхөн төлбөрийг төлөх, даатгуулагч нь даатгалын хураамж төлөхөөр харилцан тохиролцсон хэлцлийг.

Үүнтэй холбогдуулан төсөл дэх “малын эрсдэлийн даатгалын гэрээ”, “стандарт гэрээ”, “малын эрсдэлийн даатгалын стандарт гэрээ” гэснийг “даатгалын гэрээ” гэж өөрчлөн нэр томъёог жигдлэх

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар, Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

5.Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, хоёрдугаар бүлэгт шилжүүлэх:

**“... дүгээр зүйл.Даатгалын эрсдэлийн хуваарилалт**

...1.Даатгалын эрсдэлийг доор дурдсан этгээд дараах байдлаар хариуцна:

...1.1.Энэ хуулийн 8.1.1-д заасан түвшинд гарсан эрсдэлийг малчин, мал бүхий иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр;

...1.2.Энэ хуулийн 8.1.2-т заасан түвшинд гарсан эрсдэлийг даатгагч хамтын эрсдэлийн санд оруулсан хөрөнгөөр;

...1.3.Энэ хуулийн 11.1.1, 11.1.2-т зааснаас бусад эрсдэлийг давхар даатгалын компани энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан сангийн хөрөнгөөр.”

Үүнтэй холбогдуулан төслийн 8.6 дахь хэсгийг хасах.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар, Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

6.Төслийн нэгдүгээр бүлэгт доор дурдсан агуулгатай шинэ зүйл нэмэх:

**“5 дугаар зүйл.Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаанд баримтлах зарчим**

5.1.Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1.сайн дурын үндсэн дээр даатгалд хамрагдах;

5.1.2.малыг тухайн мал тоологдсон сумын нутаг дэвсгэрт даатгуулах;

5.1.3.малыг төрлөөр нь даатгуулах;

5.1.4.малын хорогдлын хувь хэмжээг сумын түвшинд тодорхойлох;

5.1.5.даатгалын нөхөн төлбөрийг тооцохдоо индекст суурилах.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар,  
Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

7.Төсөлд дор дурдсан агуулгатай шинэ зүйл нэмж, хоёрдугаар бүлэгт оруулах:

**“6 дугаар зүйл.Сумын малын хорогдлыг тогтоох, мэдээлэх**

6.1.Энэ хуульд заасан 6.2-т заасан тооллогыг тухайн жилийн 6 дугаар сарын эхний хагаст багтаан түүвэр судалгааны аргаар зохион байгуулна.

6.2.Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тухайн оны хагас жилийн мал тооллогын дүнд үндэслэн сумын малын хорогдлын тоог гаргана.

6.3.Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 6.2-т заасны дагуу тогтоосон малын хорогдлын тоог өнгөрсөн жилийн эцэст тоологдсон малын тоонд харьцуулан сумын малын хорогдлын хувийг малын төрөл тус бүрээр гаргаж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

6.4.Бүх шатны Засаг дарга Статистикийн тухай хуульд заасан статистикийн мэдээллийн талаарх бүрэн эрхээс гадна энэ хуулийн 6.3-т заасан мэдээллийг даатгуулагчид шуурхай хүргэх арга хэмжээг авна.”

Үүнтэй холбогдуулан төсөлд дараах өөрчлөлтийг оруулах:

1.Төслийн 4.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.3.“Сумын малын хорогдол” гэж жилийн эцсийн болон хагас жилийн малын тооллогын албан ёсны дүн мэдээнд үндэслэн тооцоолсон том малын хорогдлын тоог;”

2.Төслийн 4.1.13 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.13.“Том малын хорогдол” гэж тухайн жилийн оны эхнээс хагас жилийн мал тооллого хүртэлх хугацаанд зүй бусаар хорогдсон төлөөс бусад насны малын тоог;”

3.Төслийн 25 дугаар зүйлийг бүхэлд хасах.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар,  
Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

8.Төсөлд доор дурдсан агуулгатай шинэ зүйл нэмж, хоёрдугаар бүлэгт оруулах:

**“7 дугаар зүйл.Малын хорогдлын босго үзүүлэлтийг тогтоох**

7.1.Даатгалын тохиолдлыг тодорхойлох, эрсдэлийг хуваарилах зорилгоор малын хорогдлын босго үзүүлэлтийг дараах байдлаар Засгийн газар сум бүрээр тогтооно:

- 7.1.1.Даатгуулагчийн эрсдэл хүлээх буюу нэгдүгээр босго үзүүлэлт;
- 7.1.2.Даатгагчийн эрсдэл хүлээх буюу хоёрдугаар босго үзүүлэлт.

7.2.Нэгдүгээр босго үзүүлэлт нь зургаан хувь, хоёрдугаар босго үзүүлэлт нь 30 хувь байна.

7.3.Засгийн газар доор дурдсан нөхцөлийг харгалзан гурван жил тутам босго үзүүлэлтийг шинэчлэн тогтооно:

- 7.3.1.тухайн сумын малын хорогдол;
- 7.3.2.даатгалд хамрагдагсдын тоо;
- 7.3.3.хураамжийн орлогын хэмжээ;
- 7.3.4.нөхөн төлбөр олголт.”

7.4.Засгийн газар босго үзүүлэлтийг шинэчлэн тогтоохдоо нэгдүгээр босго үзүүлэлтийг нэг хувиар, хоёрдугаар босго үзүүлэлтийг тав хүртэл хувиар нэмэгдүүлэх, эсхүл бууруулж болно.

Үүнтэй холбогдуулан төслийн 4.1.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.4.“Малын хорогдлын босго үзүүлэлт /цаашид “босго үзүүлэлт” гэх/ гэж Засгийн газраас сум бүрт малын төрлөөр ялгавартай тогтоосон том малын хорогдлын хувийг;”

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар,  
Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

9.Төсөлд доор дурдсан агуулгатай шинэ зүйл нэмж, хоёрдугаар бүлэгт оруулах:

#### **“8 дугаар зүйл. Даатгалын эрсдэлийн түвшин**

8.1.Энэ хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон малын хорогдлын босго үзүүлэлтийг үндэслэн эрсдэлийн түвшинг дараах байдлаар ангилна:

8.1.1.нэгдүгээр босго үзүүлэлт хүртэлх хувиар мал хорогдсон бол эрсдэлийн бага түвшин;

8.1.2.нэгдүгээр босго үзүүлэлтээс хоёрдугаар босго үзүүлэлт хүртэлх хувиар мал хорогдсон бол эрсдэлийн дунд түвшин;

8.1.3.хоёрдугаар босго үзүүлэлтээс дээш хувиар мал хорогдсон бол эрсдэлийн дээд түвшин.”

Үүнтэй холбогдуулан төсөл дэх “Б” түвшин, “В” түвшин гэсэн нэр томъёог өөрчлөх.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар,  
Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

**10.Төсөлд доор дурдсан агуулгатай шинэ зүйл нэмж, 2 дугаар бүлэгт оруулах:**

**“ 9 дүгээр зүйл.Даатгалын хураамж**

9.1.Засгийн газраас тогтоосон босго үзүүлэлттэй уялдуулан хураамжийг доор дурдсан этгээд дараах байдлаар хариуцна:

9.1.1.хоёрдугаар босго үзүүлэлт хүртэлх эрсдэлийн дунд түвшин дэх даатгалын хураамжийг даатгуулагч;

9.1.2.хоёрдугаар босго үзүүлэлтээс давсан эрсдэлийн дээд түвшинд давхар даатгалын хураамжийг Засгийн газар.

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан хураамжтай холбогдох журмыг даатгагчдын саналыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо болон төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

9.3.Энэ хуулийн 9.1.1-д заасан журмын дагуу даатгалын хураамжийн хэмжээг даатгагчид хамтран тогтооно.”

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар,  
Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

**11.Төслийн 6.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, хоёрдугаар бүлэгт оруулах:**

**“10 дугаар зүйл. Даатгалын тохиолдол**

10.1.Энэ хуулийн 6.2-т заасны дагуу нийтэд мэдээлсэн сумын малын хорогдол нь Засгийн газраас тогтоосон нэгдүгээр босго үзүүлэлтээс давсан бол даатгалын тохиолдол бий болсон гэж үзнэ.

10.2.Гоц халдварт өвчний улмаас устгасан малын хорогдол даатгалын тохиолдолд үл хамаарна:

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар,  
Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

**12.Төслийн 6.2.2 дахь заалтыг өөрчлөн найруулж, хоёрдугаар бүлэгт оруулах:**

**“12 дугаар зүйл.Даатгалын нөхөн төлбөр**

12.1.Даатгагч нь энэ хуулийн 6.2-д заасан мэдээлэлд үндэслэн гэрээнд заасны

дагуу даатгуулагчид даатгалын нөхөн төлбөрийг малын төрөл тус бүрээр тооцон банкаар дамжуулан олгоно.

12.2.Даатгагч даатгалын нөхөн төлбөрийг хэсэгчлэн олгохыг хориглоно.

Үүнтэй холбогдуулан төслийн 6.3.4 дэх заалтыг 12 дугаар зүйлд шилжүүлэх.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар, Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

**13.**Төслийн 10.1 дэх хэсгийн “төрийн өмчит хуулийн этгээд” гэснийг “төрийн болон хувийн өмчийн оролцоотой хувьцаат компани” гэж өөрчлөх.

Үүнтэй холбогдуулан төсөлд дараах өөрчлөлтийг оруулах:

1.Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.3-10.5 дахь шинэ хэсэг нэмэх:

“10.3.Энэ хуулийн 10.1-д заасан компанийн төрийн өмчийн төлөөллийг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хэрэгжүүлнэ.

10.4.Компанийн тухай хуульд заасны дагуу давхар даатгалын компани нь хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагатай байна.

10.5.Давхар даатгалын компанитай холбогдох энэ хуульд зааснаас бусад харилцааг Компанийн тухай хуулиар зохицуулна.”

2.Төслийн 10.3 дахь хэсгийг хасах.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар, Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

**14.**Төсөлд доор дурдсан агуулгатай шинэ зүйл нэмж, 4 дүгээр бүлэгт оруулах:

**“ ... дугаар зүйл.Хувьцаа эзэмшигчдийн хурал**

....1.Компанийн тухай хуульд заасны дагуу компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.

...2.Компанийн дүрэмд заасан зарласан хувьцааг гаргах хүртэл санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.”

Үүнтэй холбогдуулан төслийн 9.3 дахь заалтыг хасах.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар, Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

15.Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“15 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөл**

15.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд санхүүгийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, даатгуулагч болон даатгагчийн төлөөллийг оруулна.

15.2.Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуульд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.2.1.даатгалын бүтээгдэхүүн актуар тооцоолол болон бусад техник судалгааг хийж, зөвлөмж гаргах, аргачлалаар хангах, шаардлагатай бол дүгнэлт гаргах;

15.2.2.компанийн стратеги болон үйл ажиллагааны дунд хугацааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

15.2.3.энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан сангийн хөрөнгийг удирдах, захиран зарцуулах шийдвэр гаргах;

15.2.4.хамтын эрсдэлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх тайланг жил бүр хэлэлцэж, сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах;

15.2.5.давхар даатгалын хураамжийн орлого, зарлагын талаар гүйцэтгэх захирлын тайланг хэлэлцэх;

15.2.6.даатгалын гэрээний загварыг батлах;

15.2.7.олон улсын давхар даатгагчид давхар даатгуулах шийдвэр гаргах;

15.2.8.шаардлагатай гэж үзвэл малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаатай холбогдуулан даатгалын компанид хяналт шалгалт хийлгэх хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд тавих;

15.2.9. хууль болон компанийн дүрэмд заасан бусад эрх, үүрэг.

15.3.Компанийн дүрэмд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх захиралд тавигдах шаардлагыг тусгана.”

Үүнтэй холбогдуулан төсөлд доор дурдсан агуулгатай өөрчлөлт оруулах:

1.Төслийн 11-14 дүгээр зүйлийг тус тус хасах:

2.Төслийн 6.1, төслийн 16.3 дахь хэсгийг тус тус хасах.

3.Төслийн 16.2 дахь хэсгийн “6 жилийн хугацаатай” гэснийг хасах.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар,  
Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

**16.Төслийн 16.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“16.4.Гүйцэтгэх захирал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.4.1.Малын индексжүүлсэн даатгалын талаарх нэгдсэн бүртгэл хөтлөх, тайлагнах;

16.4.2.улирлын санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, бусад мэдээллийг даатгагчаас авч, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, энэ талаарх мэдээллийг төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах;

16.4.3.хамтын эрсдэлийн санг удирдах;

16.4.4.Компанийн дүрэмд заасан бусад.”

Үүнтэй холбогдуулан төслийн 16.5, 16.6 дахь хэсгийг хасах.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар,  
Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

**17.Төслийн 19.1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“19.1.1.давхар даатгалын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө анх удаа бүрдүүлэхэд улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;”

Үүнтэй холбогдуулан төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан шинэ заалт нэмэх:

“19.1.2.хувьцаа худалдан борлуулсны орлого;

19.1.3.хуримтлагдсан ашиг;”

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар,  
Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

**18.Төслийн 23 дугаар зүйлийн нэрийг “Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа эрхлэх” гэж өөрчлөх:**

Үүнтэй уялдуулан төсөлд дараах өөрчлөлтийг оруулах:

1.Төслийн 23 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай шинэ зүйл нэмэх:

“23.3.Энэ хуулийн 13.1.2-т заасны дагуу давхар даатгалын гэрээ байгуулаагүй компани малчин, мал бүхий иргэн, хуулийн этгээдтэй даатгалын гэрээ байгуулахыг хориглоно.”



2.Төслийн 23.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүнийг борлуулах эрхтэй болно” гэснийг “үйл ажиллагаанд оролцоно” гэж өөрчлөх.

3.Төслийн 24 дүгээр зүйлийг бүхэлд нь хасах.

4.“малын эрсдэлийн даатгалын борлуулалт”, “борлуулалт хийх эрх”, “даатгалыг борлуулах тухай”, “борлуулалтын үйл ажиллагаа”, “борлуулалтын бүртгэл” гэсэн нэр томъёог төслөөс хасах.

5.Төслийн 8.3 дахь хэсгийн “Малын давхар даатгалын компаниас баталсан стандарт гэрээг борлуулалтын үйл ажиллагаанд хэрэглэнэ” гэснийг “батлагдсан гэрээний загварыг даатгалын үйл ажиллагаанд хэрэглэнэ” гэж тус тус өөрчлөх.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар, Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

19.Төсөлд доор дурдсан агуулгатай шинэ зүйл нэмэх:

**“... дүгээр зүйл.Малын индексжүүлсэн даатгалын сангийн төрөл**

...1.Малын индексжүүлсэн даатгалын сан дараах төрөлтэй байна:

...1.1. Даатгагчдын хамтын эрсдэлийн сан;

...1.2. Давхар даатгалын компанийн сан.”

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар, Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

20.Төсөлд доор дурдсан агуулгатай шинэ зүйл нэмэх:

**“... дугаар зүйл.Хамтын эрсдэлийн сан**

....1.Хамтын эрсдэлийн сан нь давхар даатгалын компанийн дэргэд тусдаа бүртгэлтэй, бие даасан данстай байна.

....2.Хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх, зарцуулах журмыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална.

...3.Хамтын эрсдэлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг Санхүүгийн зохицуулах хороо, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран жил бүр тогтооно.

...4.Даатгалын компани татан буугдахад хамтын эрсдэлийн сангийн өөрт оногдох хэсгийг зөвхөн энэ хуулийн 11.1.2-т заасны дагуу зарцуулах бөгөөд энэ хэмжээгээрээ даатгагчийн хуваарилагдах хөрөнгөд тооцогдохгүй.”

Үүнтэй холбогдуулан төсөлд дараах өөрчлөлтийг оруулах:

1.Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай шинэ зүйл нэмэх:

“4.1.16.”Хамтын эрсдэлийн сан” гэж даатгуулагчид учирсан хохирлыг нөхөн төлөх үүргийг хамтран хариуцахаар хэд хэдэн даатгагч хамтарч энэ хуулийн дагуу байгуулсан санг;”

2.Төслийн 8.4 дэх хэсгийг хасах.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар, Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

21.Төслийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“20 дугаар зүйл.Давхар даатгалын компанийн сан**

**20.1.Давхар даатгалын компани нь дараах бие даасан сантай байна.**

20.1.1.энэ хуулийн 4.1.9-т заасан эрсдэлээс хамгаалах сан;

20.1.2.энэ хуулийн 4.1.10-т заасан эрсдэлээс хамгаалах сан;

20.1.3.Алдагдлаас хамгаалах сан.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулахтай холбогдох журмыг Санхүүгийн зохицуулах хороо Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.”

Үүнтэй холбогдуулан төсөлд доор дурдсан өөрчлөлт оруулах:

1.Төслийн 21-22 дугаар зүйлийг бүхэлд нь хасах

2.Төслийн 4.1.9, 4.1.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.9.“Дунд түвшний эрсдлээс хамгаалах сан” гэж энэ хуулийн 8.1.2-т заасан түвшинд давхар даатгалын нөхөн төлбөр төлөх зориулалттай санг;

4.1.10.“Дээд түвшний эрсдэлээс хамгаалах сан” гэж энэ хуулийн 8.1.3-т заасан түвшинд гарсан нөхөн төлбөрийг төлөх зориулалттай санг;”

3.Төслийн 4.1.11 дэх заалтын “нөөц” гэснийг хасах.

4.төслийн 9.2 дахь хэсгийн “Алдагдлаас хамгаалах сангийн холбогдох журмыг Санхүүгийн зохицуулах хороо баталж гаргана.” гэсэн өгүүлбэрийг хасах.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар, Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

**22.Төслийн 27 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, дугаарыг өөрчлөх:**

**“27 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

27.1.Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд шүүгч, эсхүл холбогдох улсын байцаагч доор дурдсан захиргааны шийтгэлийг ногдуулна:

27.1.1.давхар даатгалын гэрээ байгуулалгүйгээр малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа явуулсан этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 60 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

27.1.2.даатгалын нөхөн төлбөр бүрэн олгоогүй, эсхүл олгохоос үндэслэлгүйгээр татгалзсан этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

27.1.3.зохих журмыг зөрчин хамтын эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулсан этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 40 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох;

27.1.4.зохих журмыг зөрчин давхар даатгалын компанийн сангийн хөрөнгийг зарцуулсан этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

27.2.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан хаагчид Статистикийн тухай болон Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

27.3.Энэ хуулийг хоёр ба түүнээс дээш удаа зөрчсөн бол малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгоно.

27.3.Энэ хуулийг зөрчсөнөөс учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр Иргэний хуульд заасны дагуу нөхөн төлүүлнэ.”

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар,  
Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

**23.Төслийн бүтцэд доор дурдсан өөрчлөлт оруулах:**

1.Төсөлд “Даатгалын тохиолдол, нөхөн төлбөр” гэсэн нэртэй шинэ бүлэг нэмж, 2 дугаар бүлэг гэж дугаарлах.

2.Төслийн 2 дугаар бүлгийг төслийн 5 дугаар бүлэгтэй нэгтгэн “Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаа” гэж өөрчилж, 3 дугаар бүлэг гэж дугаарлах.

3.Төсөлд ““Давхар даатгалын үйл ажиллагаа” гэсэн нэртэй шинэ бүлэг нэмж, 4 дүгээр бүлэг гэж дугаарлах.

4.Төслийн 4 дүгээр бүлгийн нэрийг “Малын индексжүүлсэн даатгалын сан” гэж өөрчилж, 5 дугаар бүлэг гэж дугаарлах.

5.Төслийн 5 дугаар бүлгийн нэрийг “Бусад” гэж өөрчилж, 6 дугаар бүлэг гэж дугаарлах.

Үүнтэй холбогдуулан төслийн зүйлийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг өөрчлөх:

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар, Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

**Хоёр.Найруулгын шинжтэй санал.**

1.Төсөл дэх “малын эрсдэлийн даатгал” гэснийг “малын индексжүүлсэн даатгал /цаашид “даатгал” гэх/ гэж өөрчлөн нэр томъёог жигдлэх.

2.Төслийн 1.1 дэх хэсгийн “зохицуулалт”, “малын эрсдэлийн хохирлын” гэснийг хасах.

3.Төслийн 2.1 дэх хэсэгт “Статистикийн тухай хууль” гэж нэмэх.

4.Төслийн 4.1.1 дэх заалтын “нэгж даатгуулагчид” гэснийг “даатгуулагчид” гэж өөрчлөх.

5.Төслийн 7.1.1 дэх заалтыг доор дурдсанаар найруулах:

“7.1.1. даатгуулагч нь малын төрлөө сонгон даатгуулах;”

6.Төслийн 8.1 дэх хэсгийн “малын эрсдэлийн даатгалыг борлуулах тухай гэрээ болон” гэснийг, төслийн 8.5 дахь хэсгийн “малын давхар даатгалын компаниас баталсан журамд заасны дагуу” гэснийг хасах.

7.Төслийн 8.2 дахь хэсгийг доор дурдсанаар найруулах:

8.2.Даатгагч нь зөвхөн энэ хуулийн 15.2.6-д заасан гэрээний загварыг даатгалын үйл ажиллагаанд хэрэглэнэ.

8.“ Төслийн 9.4 дэх хэсгийн “Малын давхар даатгалын компаниас тооцсон “В” түвшний” гэснийг “энэ хуулийн 9.1.2-т заасан” гэж өөрчлөх.

9.Төслийн 9.2 дахь хэсгийн нэг дэх өгүүлбэрийг доор дурдсанаар найруулах:

“9.2.Засгийн газар давхар даатгалын компанийг үүсгэн байгуулахад төрөөс оруулах хувь хөрөнгө болон алдагдлаас хамгаалах санг бүрдүүлнэ.”

10.Төслийн 23.1.2 дахь заалтыг доор дурдсанаар найруулах:

23.1.2.Энэ хуулийн 10.1-д заасан компанитай давхар даатгалын гэрээ байгуулсан байх.

11.Төсөл дэх “Удирдах зөвлөл” гэснийг “төлөөлөн удирдах зөвлөл” гэж өөрчлөн нэр томъёог жигдлэх.

12.Төслийн 6.3.3 дахь заалтыг доор дурдсанаар найруулах:

“6.3.3.нөхөн төлбөр олгох нэгдүгээр босго үзүүлэлт.”

13.Төслийн 18.1 дэх хэсгийн “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд” гэснийг “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд” гэж өөрчлөх.

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар, Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

**Гурав.Даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар**

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар найруулах:

“1 дүгээр зүйл.Даатгалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

**1/ 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг:**

“3.5.Малын индексжүүлсэн даатгалын харилцааг хуулиар зохицуулна.”

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар, Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

**Дөрөв.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар найруулах:

“1 дүгээр зүйл.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

**1/ 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт**

“3.1.8.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасан даатгалын үйл ажиллагаа;”

**2/ 6 дугаар зүйлийн 6.2.7 дахь заалт**

“6.2.7.малын даатгалын үйл ажиллагааны чиглэлээр Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасан.”

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар,  
Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

**Тав.Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар найруулах:**

**“1 дүгээр зүйл.Төслийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “в” заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

**в/ мал, тэжээвэр амьтдын тооллогыг жил тутам, малын хагас жилийн тооллогын түүвэр судалгааг хуульд заасан хугацаанд;”**

**Санал гаргасан:Улсын Их Хурлын гишүүн А.Бакей, Б.Гарамгайбаатар,  
Д.Зоригт, Л.Энх-Амгалан, Я.Содбаатар, Ц.Цолмон**

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО**